

“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 1

Рашаант

Хурал 2026 оны 04 сарын 30-ны өдрийн 14,00 цагаас компанийн хурлын танхимд эхлэв.

Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хуралдуулах товыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3-р сарын 17-ны өдрийн 02 тоот тогтоолоор гаргасан бөгөөд хурлын зарыг “Өнөөдөр” MN өдөр тутмын сонины 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн №050 /8354/, 4 дүгээр сарын 1-ний өдрийн №059 /8363/ дугааруудад тавьж нийтлүүлсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 01/360 тоотгоор гаргуулсан болно.

“Талын гал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрээр Тооллогын комиссын даргаар компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Түвшинбаярыг, гишүүдээр компанийн нүүрсний борлуулагч Х.Шинэбаяр, нярав Г.Насанжаргал нарыг тус тус томилсон болно.

Тоологын комиссын танилцуулсанаар хуралд тус компанийн нийт 694264 хувьцаа эзэмшигч, 26 хүн хуралд оролцохоос нийт 683546 хувьцаа эзэмшигч 3 хүн ирж, хурлын ирц 98,5 хувь болсон тул хурлыг 14,00 цагаас эхлүүлэв.

Тус компанийн хувьцаа эзэмшигч С.Янжмаагийн санал болгосноор хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, хувьцаа эзэмшигч У.Батсуурь, нарийн бичгийн даргаар хувьцаа эзэмшигч С.Цэрэндондов нарыг санал нэгтгэйгээр сонгов.

Хурлын дарга У.Батсуурь “Талынгал” ХК-ийн 2026 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг хуралд оролцогчдоор хэлэлцүүлэн батлуулав. /Хурлаар хэлэлцсэн асуудлууд, хурлын дэгийг хавсаргав./

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу, хурлын дэгийн хүрээнд хэлэлцэж, урьдчилан зөвшилцөж тохиролцсоны дагуу хэлэлцсэн асуудал тус бүрээр хувьцаа эзэмшигчид саналаа чөлөөтэй илэрхийлж, хариулт авч байв.



Хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ч.Түвшинбаяр оролцсон бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар бусад гишүүдтэй ижил байр суурьтай байсан болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Болдбаатар, П.Дашпүрэв нар компанийн хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хуралд оролцоогүй болно.


Хурлаар хэлэлцсэн асуудлаар гаргах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдийн гаргасан саналыг Тооллогын комисс саналын хуудсаар авч, нэгтгэн, баталгаажуулж, Тооллогын комиссын гаргасан 01 тоот тогтоолыг комиссын дарга Ч.Түвшинбаяр танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлаас тооллогын комиссын дээрхи шийдвэрийг зөвшөөрч дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд:


1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тухай тогтоол
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн боломжийн бодит байдлыг харгалзан үзэж, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах нь зүйтэй гэж үзэв.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгогдсоныг баталгаажуулах тухай тогтоол
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах тухай тогтоол эдгээр болно.

Хурал хэлэлцэх асуудлаа хэлэлцэж 16,50 цагт дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  С.ЦЭРЭНДОНДОВ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:
ХУРЛЫН ДАРГА  У.БАТСУУРЬ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН:



Ч.ТҮВШИНБАЯР

